

/Төслөөр/



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

/2021-2025/

ДОРНОГОВЬ МСҮТ-ийн СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЕРӨНХИЙ АГУУЛГА

1. ОРШИЛ

2. АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, УРИА, ҮНЭТ ЗҮЙЛС

3. 2025 ОН ХҮРТЭЛХ СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТУУД

1. . СУДАЛГАА, ИННОВАЦИЙН ОНОВЧТОЙ БҮТЭЦ, ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ

2. . НЭЭЛТТЭЙ, ӨРСӨЛДӨӨНД СУУРИЛСАН ЧАНАРТАЙ СУРГАЛТЫН ТОГТОЛЦООГ
ТӨЛӨВШҮҮЛЭХ

3.3. СУРАЛЦАГЧДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ

3.4. СУРГАЛТ, ДАДЛАГЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ

3.5. УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ОНОВЧТОЙ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ

3.6. НИЙГМИЙН ХӨГЖИЛД ОРУУЛАХ ХУВЬ НЭМРИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ

4. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ, ХЯНАЛТ, ТОДОТГОЛ

ОРШИЛ

Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны харьяа Дорноговь аймаг дахь Магадлан итгэмжлэгдсэн Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв нь мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, зорилгыг бүрэн хэрэгжүүлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн үр чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах үүрэг бүхий мэргэжлийн боловсрол олгодог 34 жилийн түүхтэй сургалтын байгууллага юм. Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн үр чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршдог билээ.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь АДХГЗ-ны 1986 оны 10 дугаар сарын 30-ны 100 тоот тогтоолоор Дундговь аймгийн барилгын техник мэргэжлийн сургуулийн салбар сургууль болж байгуулагдсан. Анх 27 сурагчтай үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 1987 онд Улаанбаатар хотын барилгын нэгдүгээр Техник мэргэжлийн дунд сургуулийн салбар сургууль, 1989 оны долдугаар сарын 15-нд АБЯ-ны 189 тоот тушаалаар Барилга хөдөө аж ахуйн техник мэргэжлийн сургууль болон бие дааж, 1992 оноос Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв болон өргөжиж үйлдвэрлэл, үйлчилгээ, уул уурхайн чиглэлээр орон нутагтаа мэргэжилтэй ажилтныг бэлтгэж ирсэн түүхтэй. Тус сургууль нь мэргэжлийн боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх, мэргэжлийн үр чадвар эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулж, барилга, техник, үйлдвэрлэл, үйлчилгээ, нийтийн хоолны салбарт олон зуун мэргэжилтэй ажилтныг бэлтгэн гаргаж, өдгөө мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын нэр хүндтэй сургуулиудын нэг болсон байна. Сургуулийн захиргаанаас түгээмэл мэргэжил болон үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлээр бодлого барьж, эрэлт хэрэгцээгээ судлан ажилласны үр дүнд одоог хүртэлх хугацаанд ХАА, барилга, уул уурхай, үйлчилгээний чиглэлийн 20 гаруй мэргэжлээр 15000 орчим залуусыг мэргэжилтэй ажилтан болгон төгсгөж гаргасан байна. Байгууллагын багш, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, суралцагчдын сурч хөдөлмөрлөх орчныг сайжруулах, мэдээлэл технологийн хангамжийг орчин үеийн дэвшилтэт үйлчилгээний түвшинд хүргэхэд зориулж нэг тэрбум долоон зуун сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар орчин үеийн сургалтын стандартад нийцэхүйц орчин бүрдүүлснээр “Нийгмийн даатгалын итгэлтэй түнш”, “Онцлох боловсролын байгууллага”, “Сургалтын шилдэг орчин бүрдүүлсэн сургууль”, “Санхүү эдийн засгийн шилдэг үзүүлэлттэй сургууль”, стандарт хэрэгжүүлэгч байгууллагаар тодорхойлогдож “Стандарт-2018” цом, өргөмжлөл, 2018 оны ажил үйлсээрээ салбартаа тэргүүн байр эзэлсэн зэрэг олон амжилтыг хамт олныхоо хүчин чармайлт, идэвх санаачилгаар бий болгосон.

Сүүлийн гурван жилийн хугацаанд хөрш зэргэлдээ БНХАУ-ын ӨМӨЗО-ы Ажил мэргэжлийн дээд сургуультай холбоо тогтоосноор багш болон оюутан солилцооны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. ӨМӨЗО-ы Шилийн гол, Хөх хот, Бугат зэрэг хотын ижил төстэй сургуулиуд дээр сургалт аялал, туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулснаар 5 удаагийн хөтөлбөрөөр 79 суралцагч, 26 багш хамрагдаад байна.

СЭЗИС-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, цахим сургалтаар багш суралцагчдыг болоод орон нутгийн бусад салбарын боловсон хүчнүүдийг ажлын байран дээрээ мэргэжлээ дээшлүүлэх, суралцагчдын хувьд орон зай, цаг хугацаанаас үл хамаарч хүссэн мэргэжлээрээ, чанартай сургалтад хамрагдах, ялангуяа хувь хүн бие даан суралцах өргөн боломжийг нээж өгсөн. Япон Улсад төгсөгчдийг үргэлжлүүлэн сургах, мэргэжлээр нь дадлагажуулах, гадаад харилцааг өргөжүүлэх зорилгоор ижил үйл ажиллагаа явуулж буй сургууль, холбогдох газартай харилцаа тогтооход дэмжлэг хүсэх, өөрийн сургуулийн багш ажилчдыг тус улсад дадлага хийх, мэргэжил дээшлүүлэх, хамтран ажиллах зорилгоор 'MICA MONGOLIA' Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй сүүлийн хоёр жил хамтран ажилласнаар Фукоука, Канагава мужуудад 9 багш, ажилтан мэргэжил дээшлүүлэх 45 хоногийн хөтөлбөрт хамрагдаад ирсэн. Япон улсад ажиллах, сурах сонирхолтой залууст зориулсан япон хэлний эрчимжүүлсэн сургалтыг өөрийн хичээлийн байранд тогтмол зохион байгуулж байгаа төдийгүй сургалтын үйл ажиллагааг жигдлэн, сургалтын орчныг орчин үеийн нөхцөл шаардлагад нийцүүлэн тохижуулж, суралцагчдын үр чадвар, төлөвшил, зөв хандлагыг дээшлүүлэхийн төлөө бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Хувьсан өөрчлөгдөж буй гадаад орчны хүчин зүйлүүдийн өөрчлөлтөд оновчтой хариу өгөх, дэлхийн боловсролын хөгжлийн цаашдын хандлагад нийцүүлэн хөгжих, мэргэжлийн боловсролын салбарт тодорхой чиглэлүүдээр манлайлагч байх, сургууль болон суралцагчдынхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, сургуулийн чадавхыг дээшлүүлэн хүчирхэгжүүлэх, Монголын мэргэжлийн боловсролын хөгжлийг тодорхойлогч жишиг сургууль болох үүднээс дараагийн таван жилд /2021-2025/ хэрэгжүүлэх бодлого, хүрэх түвшинг тодорхойлсон энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулсан болно.

Ирэх таван жилд тус сургууль нь “Ур чадвартай- бүтээлч оюутан ” бэлтгэх, түүнд тохирсон менежментийг нэвтрүүлэхэд голлон анхаарч ажиллах болно.

Стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр ойрын таван жилд цаг үеийн шаардлага, даяарчлагдаж буй зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр туршиж үр дүнг тооцох, сургалтын шинэлэг технологи болон таатай орчин нөхцөл бүрдүүлэх, гадаадын ижил төстэй сургуулиудтай хамтарсан мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, техникийн боловсрол олгох сургалтын төлөвлөгөөг дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгатай уялдуулж, боловсруулан батлуулах, 2-оос доошгүй техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийлгэх, мэдээллийн технологийн эрчимтэй хөгжлийг дагасан онлайн хичээлийн сан бүрдүүлэх, судалгаа шинжилгээний бүтээлүүд, боловсон хүчний оновчтой бодлого, чадварлаг бүтээмжтэй багш нараар өөрийн салбартаа ТЭРГҮҮЛЭГЧ нь байх болно.

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, УРИА, ҮНЭТ ЗҮЙЛС

Алсын хараа (Vision): **УР ЧАДВАРААР- ХӨГЖИЛД ХҮРЭХ**

Эрхэм зорилго (Mission statement):

МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРААР - БАЯЛАГ БҮТЭЭГЧДИЙГ ТӨРҮҮЛНЭ

Уриа (Poster): *УР ЧАДВАР, ЗӨВ ХАНДЛАГА, ТӨЛӨВШИЛ*

Үнэт зүйлс (Values):

- *СУРАЛЦАГЧАА ДЭЭДЛЭХ*
- *СОНГОЛТ БА ӨРСӨЛДӨӨН*
- *НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА*
- *ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭХ*
- *САНААЧЛАГЧ БА БҮТЭЭГЧ*

Гадаад орчны PEST шинжилгээний үр дүн

Улс төрийн хүчин зүйл /P/

- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль нь энэ салбарт үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх зүйн харилцааг зохицуулна.
- Төрөөс мэргэжлийн боловсрол олгогч байгууллагууд болох коллеж, МСҮТ-ийг дэмжиж, суралцагчдад тэтгэлэг олгож байна.
- МСҮТ, коллеж төгсөгч дараагийн шатны сургуульд суралцах боломжтой
- Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого гарсан. Энэ бодлогын хүрээнд төмөр замын мэргэжилтэй ажилтан бэлтгэх асуудалд төрийн бодлого тусгагдсан.
- Орон нутгийн тэргүүлэх чиглэлийг түшиглэн хөгжих өргөн боломжтой.
/ боловсруулах үйлдвэр, уул уурхай, дэд бүтэц, аялал жуулчлал/
- START UP буюу Гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр хэрэгжиж байна.

Эдийн засгийн хүчин зүйлс /E/

- Төрийн өмчит сургуулийн санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал хэдий ч баталгаатай.
- Танилцах, үйлдвэрлэлийн, төгсөлтийн өмнөх дадлагыг орон нутагт хийдэг.
- Төмөр замын сүлжээ бүхий газруудад төмөр замын мэрэгжлийн ангиуд Замын даргын зөвшөөрлөөр дадлагат гардаг. Дадлагын үед унааны зардал, хөдөлмөр хамгааллын зардал шаардлагатай. Цаашдаа төлбөртэй дадлага хийх шаардлага үүсэх магадлал өндөр.
- Техник технологийн хөгжлийн хурдтай хөл нийлүүлэх үүднээс жил бүр техникийн болон программ хангамжийн шинэчлэлт хийх шаардлага тулгардаг. Сургалтын орчны шинэчлэлт хийхэд санхүүгийн хүндрэл байнга тулгарч байдаг.

Нийгмийн хүчин зүйл /S/

- Нутгийн захиргааны байгууллага, ажил олгогчид, нийгмийн түншлэлийн харилцаа бэхжиж байгаа.
- Сургалтын технологи, сургалтын орчин бүрдүүлэх тал дээр ажил олгогч байгууллагыг түшиглэх, хамтарч ажиллах шаардлагатай.
- Иргэн бүрт суралцах боломжийг хүртээмжтэй тэгш олгож, суралцагч болон багш, ажилтны нийгмийн асуудлыг анхаарах шаардлагатай.

Технологийн хүчин зүйл / T/

- Сургалтын цахим программуудыг өргөнөөр нэвтрүүлэх
- Сургалтыг цахим хэлбэрээр явуулах
- Сургалтын полигон байгуулах өөрийн сургуулийн орчинд үйлдвэрлэлийн дадлага хийх боломжийг бий болгох.
- Сургалтын орчинг иж бүрэн автоматжуулах, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэх

Байгууллагын SWOT шинжилгээний үр дүн

Давуу тал “Д”	Сул тал “С”
<ul style="list-style-type: none"> ✓ Багш нар компьютер, принтер, бусад техник хэрэгслээр бүрэн хангагдсан. ✓ Бүх анги танхим проектор, самбар, дэлгэц зэргээр тоноглогдсон. ✓ Төгсөгчдийг ажлын байраар хангах хөдөлмөрийн зах зээл хангалттай. ✓ Орон нутагт мэргэжлийн боловсролыг үнэ төлбөргүй олгож байгаа ганц сургууль ✓ Өрсөлдөгч байгууллагын нөлөөлөл багатай. 	<ul style="list-style-type: none"> ✓ Сургуулийн хичээлийн байр шаардлага хангахгүй, анги танхим, номын сангийн хүрэлцээ багтаамж муу. ✓ Гадаад харилцаа сул. ✓ Хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг . ✓ Үндсэн мэргэжлийн хөрвөх чадвар бага. ✓ Мэргэжлийн боловсролын газарт төмөр замын мэргэжлийн чиглэлд дэмжлэг бага. ✓ Ажлын байр, зах зээлийн судалгаатай элсэлт авахгүй байгаагаас эрэлт нийлүүлэлтийн харьцаа алдагдаж байгаа. ✓ Багш ажилтныхаа боловсрол, нийгмийн асуудлыг шийдвэрлэх санхүүгийн боломж муу.
Боломж “О”	Аюул занал “Т”
<ul style="list-style-type: none"> ✓ Төрөөс мэргэжлийн боловсролыг дэмжсэн эрх зүйн орчин бүрдсэн. ✓ Ажил олгогчтой хамтран сургалт зохион байгуулах, багшийг хөгжүүлэх боломжтой. ✓ Захиалгат болон түр сургалтуудыг зохион байгуулах. ✓ Бүх шатны төсөл хөтөлбөрт хамрагдах, төсөл хэрэгжүүлэх, санаачлах. ✓ Өөрийн сургуулийг түшиглэн дадлагын бааз, лабораториудыг шинээр байгуулах. ✓ Мэргэжлийн цар хүрээг нэмэгдүүлж сургуулийн өрсөлдөх, хөрвөх чадварыг сайжруулах. ✓ Гадаад харилцааг хөгжүүлэх. ✓ Багш нарыг тодорхой судалгаа шинжилгээний ажилд татан оролцуулах замаар хөгжүүлэх. ✓ Сургуулийг техникийн боловсрол олгодог болгож өргөжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> ✓ Элсэлтийн зохион байгуулалтад өөрчлөлт хийхгүй бол суралцагчдын чадвар суларсан. /сонгон шалгаруулах/ ✓ 2,5 жил суралцаад төгссөн суралцагчид насанд хүрээгүй байдаг. Сургалтын төлөвлөгөөнд удаа дараагийн өөрчлөлт оруулдаг. ✓ Техник технологийн хөгжилд тулгуурлан сургалтыг зохион байгуулаагүйгээс зарим нэг мэргэжил хоцрогдолд хүрсэн. ✓ Ижил төстэй сургууль, сургалтын төвүүд байгуулагдсанаар элсэгчдийн тоо цөөрөх, төгсөгчдийн ажлын байраар хангагдах боломж муудах. ✓ Санхүүгийн хувьд биеэ даах эрх зүйн орчин бүрдээгүй

ДҮГНЭЛТ

PEST, SWOT шинжилгээнд хийсэн дүгнэлтээр сургуулийн нэн түрүүнд тулгамдсан асуудал нь сургуулийн байр юм. Байрны асуудал шийдэгдсэнээр сургалтын орчны бүрдүүлэлт, техник технологийн шинэчлэлт хийх боломжтой болно.

Өрсөлдөгч байгууллага байгаа хэдий ч зөв менежментийн бодлого баримтлан ажиллавал аюул занал багатай.

Төрийн өмчийн сургуулийн хувьд үйлдвэрлэлийн дадлага болон ажлын байрны хангалт сайтай. Гэхдээ техникийн шинэчлэлт, сургалтын арга технологид байнгын дэвшил хийхгүй бол хоцрогдол нүүрлэх аюултай.

Техникийн боловсрол олгодог сургуулиудтай хамтран шаталсан сургалтыг хэрэгжүүлэх шаардлагатай үүнтэй холбоотой гэрээ байгуулж хамтарч ажиллах

Сургуулийг эдийн засгаар дэмжих төсөл хөтөлбөрүүд санаачлах, хэрэгжүүлэх.

Багш, суралцагчдыг судалгааны ажилд татан оролцуулах, судалгааны ажлыг дэмжих, багшийн мэргэжлийг дээшлүүлэх, багшийн хувийн ур чадварыг нэмэгдүүлэх тал дээр анхаарах шаардлагатай.

Гурав. 2021- 2025 ОН ХҮРТЭЛХ СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТУУД

3.1. Судалгаа, инновацийн оновчтой бүтэц, тогтолцоог хөгжүүлэх

Сургуулийн өнөөгийн нөхцөл байдлаас үзэхэд, судалгаа шинжилгээ, инновацид холбогдолтой журмуудыг баталж, бүтцийг бий болгосон хэдий ч судалгаа шинжилгээний ажил хийгдэж эхлээгүй, дорвитой ахиц гараагүй, бүтэц үр өгөөж муутай ажиллаж байна. МСҮТ-ийг уламжлалт аргад суурилсан тогтолцооноос судалгаа, инновацид тулгуурласан, өрсөлдөөнд суурилсан тогтолцоонд шилжүүлэх шаардлагатай байна. Сургалтын хэлбэрийг төрийн дэмжлэгт илүү тулгуурлах хэдий ч тэнхим хоорондын төлөвлөгөөт судалгаа шинжилгээний ажлыг дэмжсэнээр багш нарын багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах нь чухлаар тавигдаж байна. Судалгааг ч олон талаас нь багийн системээр нарийвчлалтай хийх боломжтой болно.

Судлаач багш бий болох, цаашлаад судлаач багшийн бүтээлч сэтгэхгүйтэй шавь нар төрөх сайн талтай хэмээн үзэж байна.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Шалгуур үзүүлэлт
Судалгааны нээлттэй, өрсөлдөөнт, уян хатан тогтолцоог нэвтрүүлэх	Өрсөлдөөний шинжтэй урамшуулал олгох	Багш хувиараа болон тэнхимээрээ, эсвэл бэлдсэн оюутан нь сургуулийн, бүсийн, улсын, олон улсын тэмцээн уралдаанд оролцсон байх
Тэнхим хоорондын, багш нар хоорондын өрсөлдөөн бий болох	Судалгаа шинжилгээний ач холбогдлыг харгалзан урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх	Багшийн ажлын төлөвлөгөөнд судалгааны ажил багтсан байх, тухайн судалгааны ажлын явц, биелэлт, хэрэгжилтийг хянах
Эрдэм шинжилгээ, инновацийн таатай орчин бүрдэх	Инновацийн үр шимийг санаачлагчид ашигтайгаар хуваарилах тогтолцоог бий болгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх	Улсын, бүсийн, дүүргийн, олон улсын эрдэм шинжилгээний хуралд өгүүлэл хэлэлцүүлэх, салбарын болон улсын хэмжээний шилдэг бүтээлийн уралдаанд оролцсон байдал, тухайн судалгааны ажил нь салбарт нүүрлээд буй хүндрэл бэрхшээлийг шийдсэн байх
Суралцагчдыг хөгжүүлэх боломжийг судалж, бичил үйлдвэрлэл хөгжих суурь бий болгох	Суралцаж буй чиглэлээрээ уралдаант төсөл санаачлах, түүнийг хэрэгжүүлэх	Эдийн засгийн хувьд үр ашигтай, мэргэжлийн чиглэлээс үл хазайсан төсөл нь хэрэгжиж, үр дүнгээ өгөх
Сургалтын бодлого орчин үеийн чиг хандлагатайгаар хөгжих	Сургалтын орчин бүрдүүлэлт, сургалтын үйл ажиллагаанд техникийн дэвшлийг нэвтрүүлэх	Багш, ажилчдын сургалтын арга технологид шинэчлэлт хийж, автоматжуулах, цахимжуулах төслийн үр дүнгээр

3.2. Нээлттэй, өрсөлдөөнд суурилсан чанартай сургалтын тогтолцоог төлөвшүүлэх

Сургалтын чанар, хөтөлбөрийн агуулга, багшийн мэдлэг, ур чадвар, заах арга хэлбэр, элсэгчдийн чанар, оюутанд үзүүлэх дэмжлэг туслалцаа, үнэлгээ, суралцах боломж зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай.

Сонголтоос өрсөлдөөн, өрсөлдөөнөөс чанарыг төрүүлдэг, ахисан түвшний сургалт, салбар дундын судалгааг хөгжүүлэх, тохиромжтой бүтэц, зохион байгуулалтыг бий болгох замаар сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлж, хөтөлбөрүүдээ байнга шинжилж, шинэчлэх замаар орчин үеийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадах ур чадвартай шилдэг мэргэжилтнийг бэлтгэх боломжтой гэж үзэж байна.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад чадамжид суурилсан сургалтын системийг төгөлдөржүүлж, сургалт, судалгааны үйл ажиллагаа, хөтөлбөрийг тасралтгүй өөрчлөн сайжруулдаг, нэг талаас суралцагчид багш нараас байнгын хүчин чармайлтыг шаарддаг, нөгөө талаас хөдөлмөрлөж буй багш, суралцагчдад илүү их боломжийг бий болгодог өрсөлдөөнт тогтолцоог бүрдүүлж, эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай бүтцийг бий болгох замаар сургуулийн бүхий л түвшний сургалтыг өөрөө өөрийгөө хөгжүүлж чаддаг, биеэ даасан хөгжлийн замд оруулахад чиглүүлнэ. Суралцагч нэг бүрийн авьяас чадвар, хүсэл сонирхол, ирээдүйн хэрэгцээ шаардлагад үндэслэн мэргэжлээрээ хөрвөх чадвартай төгсөгчийг хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэх боломжийг олгоно.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Шалгуур үзүүлэлт
Элсэлтийн чанарыг дээшлүүлэх, сургах, судалгааны ажилд татан оруулах тогтолцоо бий болох	Элсэлтийн журам шинэчлэх, сургалтын технологи шинэчлэх, суралцагчийн бүтээлч сэтгэлгээг дэмжих	Элсэлтийн үйл ажиллагаа өрсөлдөөний хэв шинжийг бүрэн агуулсан байх, үр дүнтэй судалгааны ажлууд, багш шавийн хамтач ажиллагаа үр дүнгээ өгөх
Мэргэжлийн цар хүрээ нэмэгдэх, хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх тогтолцоо бий болох	Салбар хоорондын судалгаа, техникийн хөгжлийн судалгаа, хөрвөх мэргэжлээр суралцах боломжийг нээх	Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийгдсэн эсэх, мэргэжлийн цар хүрээ тэлсэн эсэх, мэргэжлүүдийн хөрвөсөн байдал
Сонголтоос өрсөлдөөн, өрсөлдөөнөөс чанарт шилжсэн нээлттэй сургалтын арга технологи бий болох	Суралцагч, багшийн уялдаа холбоог сайжруулж, цахим сургалтын үр дүнтэй олон арга, технологийг турших, дүгнэх	“www.amjilt.com” системийг бүрэн нэвтрүүлэх
Инженерийн сэтгэлгээг төлөвшүүлэх, дэмжих тогтолцоо бий болох	Мэргэжлийн үр чадварын уралдаанууд, эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулах, багш суралцагчдын хамтарсан судалгааны ажлуудыг дэмжих	Багш суралцагчдын хамтач ажиллагаанууд, тэдний бүтээлийн үр дүн, багш оюутны хамтын бүтээл хийх орчин бүрдүүлэх
Тэнхимүүд өөрсдийн бизнес төлөвлөгөөтэй болох	Түр сургалт, мэргэжлийн зэрэг ахиулах сургалтыг хичээллүүлэх, тэнхимийн багш нарын хамтарсан болон бие даасан бүтээл түүрвэх, түүнийг борлуулах	Тухайн тэнхимийн ажлын төлөвлөгөө, хийж буй ажлын үр дүнгийн тооцоо

3.3. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээг хөгжүүлэх

Суралцагчдын суралцах амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, тэдэнд хүртээмжтэй, тэгш шударга үйлчилгээг үзүүлэхийн тулд оюутанд хүргэх үйлчилгээний стандартыг боловсруулж, батлан мөрдөх шаардлагатай. Үүний зэрэгцээ шинийг санаачлагч, бүтээлч суралцагчийг судалгаа шинжилгээ хийх, багшлах ажилдаа татан оролцуулах, ажил олгогчдын нэрэмжит тэтгэлэгт хамруулах, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих зэргээр ажиллаж, амьдрах, суралцах орчин нөхцөлийг нь сайжруулахад чиглэсэн бусад арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Шалгуур үзүүлэлт
Суралцагчдад хүргэх үйлчилгээний стандарт батлагдаж хэрэгжих	Суралцагчийн дүрэм, журмыг шинэчлэх, оюутанд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээний зураглалыг хийж, стандартыг батлуулж, мөрдөх	Суралцагчид үзүүлэх үйлчилгээний стандарттай болсон байх, оюутны сурч ажиллах нөхцөлийг сайжруулсан байдал
Ажил олгогчийн нэрэмжит тэтгэлэгт хамруулах	Суралцагчид тэтгэлэг олгох журам боловсруулах, ивээн тэтгэх түншлэгчдийн судалгаа гаргах, шийдвэрлүүлэх	Улсаас өгч байгаа тэтгэлгээс гадна сургуулийн зүгээс өдөөх, идэвхжүүлэх, тусалж дэмжих зорилго бүхий тэтгэлэг, тэтгэмжийн хэмжээ, багшийн хүлээсэн үүрэгт суралцагчийн үзүүлсэн нөлөөллийн үр дүнг тооцох
Суралцагчдын хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог бүрдүүлэх	Суралцагчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, төрийн болон төрийн бүс байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах	Хичээл сургалтыг орхигдуулалгүй орлогоо нэмэгдүүлсэн, мэргэжлийн үр чадвараа сайжруулсан суралцагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдалд үнэлэлт өгөх
Судлаач, шинийг санаачлагч суралцагч бий болох	Суралцагчдыг бие даан судлах, шинийг бүтээх, санаачлах ажилд татан оролцуулах, дэмжих	Суралцагчийн бүтээл, гаргасан амжилтууд, шавиараа дамжуулан багшийн бүтээл нийтэд түгсэн байдал
Суралцагчийн авьяас, хүсэл сонирхолд судалгаа хийж, мэрэгжлээрээ хөрвөх чадвартай болгох	Хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх замаар хэрэгцээ шаардлагад нь нийцсэн үйл ажиллагаа зохион байгуулах	Ажил олгогчийн шаардлагад нийцсэн, ажлын байран дээр үндсэн мэргэжлээс гадна хөрвөх чадвартай болсон байдал
Суралцагчийн сурч, хичээллэж, амьдрах таатай орчин, ахуй бүрдэх	Дотуур байр, анги танхим, сургуулийн орчны тав тухтай байдлыг хангах	Сургуулийн орчинд халуун дулаан уур амьсгал бүрдсэн, суралцагчдын хичээлд хандах хандлага сайжирсан байх
Төгсөгчдийг ажлын байранд зуучлах	Нэмэх /	Нэмэх

3.4. Сургалт, дадлагын орчныг сайжруулах

Орчин үеийн сургуулиудын сургалт, дадлага, судалгааны хэрэгцээ шаардлагыг хангасан, судлаач багш болон суралцагч бие даан хөгжих боломжийг бүрдүүлсэн, тэдэнд суралцах, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, тав тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх нь даяарчлагдаж буй нийгэмд өрсөлдөх чадвартай төгсөгч бэлтгэх, ур чадвартай, зөв хандлагатай, төлөвшсөн мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд онцгой чухал ач холбогдолтой. Шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн ололт, амжилтад тулгуурласан мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, судалгааны нээлттэй лабораториуд, электрон номын сан, цахим сургалтыг боловсронгуй болгоход чиглэсэн мульт медиа төв, сургалтын полигоныг байгуулах зорилтуудыг дэвшүүлж байгаагийн зэрэгцээ судалгааны төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгө босгох нэгжийг ажиллуулж сургуулийн алс хэтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн сургуулийг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Шалгуур үзүүлэлт
Шилдэг технологид суурилсан мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлнэ	Сургалтын цахим бүртгэлийн программ, цахим сургалтын системийг боловсронгуй болгох, Цахим номын сан, цахим шалгалтын системийг нэвтрүүлэх	Сургалтын арга технологи хэрхэн автоматчилагдсан, сургалтад орчин үеийн арга барил нэвтэрсэн эсэх
Сургалтын лабораториудтай болох, сургалтын полигоныг иж бүрэн тоноглох	Салбарын шинэчлэлт, техник технологийн дэвшлийг судлах, сургалтын полигоныг баяжуулах, сэлбэх, тоноглох	Мэргэжлийн чиглэл, онцлогт нийцсэн лабораторын хүртээмж, сургалтын полигон орчин үеийн шаардлагад нийцэж байгаа эсэх
Хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах	Мэргэжлийн боловсролыг дэмжиж ажилладаг донор байгууллагуудад төсөл хүргэж, санхүүгийн дэмжлэг авах	Төслийн үр дүнтэй хэрэгжиж байгаагаар
Сургуулийг хотхон болгон хөгжүүлэх төсөл боловсруулах	Сургуулийн хотхон байгуулах зураг төсөлтэй болох, хотхоныг бий болгох, хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх	Сургуулийн хотхон байгуулах төсөл, түүний хэрэгжилтэд дүгнэлт өгөх, санхүүгийн эх үүсвэр бий болгосон, асуудлыг шийдвэрлэсэн байдлаар

3.5. Удирдлага, хүний нөөцийн оновчтой бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх

Сургуулийн удирдлагын үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, хариуцлагатай, оролцоотой байх зарчмуудад тулгуурлан явагдах бөгөөд нэг талаас, удирдлагын үйл ажиллагаанд орчин үеийн техник технологийн дэвшил, түүний дотор мэдээллийн нэгдсэн системийг ашиглах, нөгөө талаас ажлын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн дэвшилтэт аргууд, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг ашиглах замаар үйл ажиллагааны дээрх зарчмуудыг хангах болно. Удирдлагын үйл ажиллагааг боловсронгуй болгохын зэрэгцээ шилдэг багш, судлаачид ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүний нөөцийн удирдлага төлөвлөлтийг боловсронгуй болгох талаар дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Шалгуур үзүүлэлт
Дотоод үйл ажиллагааны нэгдмэл стандартыг бий болгож, нэвтрүүлэх	Сургуулийн дотоод үйл ажиллагааны дүрэм журмуудыг боловсронгуй болгож мөрдүүлэх, стандартчилагдсан үйлчилгээ болгон хөгжүүлнэ.	Сургуулийн орчинд бүх төрлийн харилцаа дүрэм, журмаар зохицуулагдсан эсэх, дотоод зөрчил, маргаан арилсан байдал, ёс зүйн зөрчил бүүрсах эсэх
Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бүтээлтэй шилдэг судлаач, багш, инженер багш нарыг татах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Багш судлаачдын хөдөлмөрлөх орчин нөхцлийг сайжруулах, багшийг хөгжүүлэх хөтөлбөр	Багш нарын мэргэжлийн зэргийн болон боловсролын зэрэг цол дээшилсэн байдал, багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанууд
Хүний нөөцийн удирдлага, төлөвлөлтийг боловсронгуй болгох	Удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх Сонголт ба өрсөлдөөнийг дэмжсэн хүний нөөцийн бодлоготой	Удирдлагын нэгдсэн мэдээллийн систем нэвтэрсэн, багш ажилчдын чадварыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн байх, сонголт ба өрсөлдөөнийг дэмжсэн хүний нөөцийн бодлого батлуулж хэрэгжүүлсэн байх
Багшийн хөгжлийг дэмжих	Багшийн хөгжлийг үнэлж, дэмжих, сургуулиас тодорхой төлөвлөгөө гаргаж ажиллах	Багшлах боловсон хүчний чадамж жил тутамд дээшилсэн байх

3.6. Нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг дээшлүүлэх

Орчин үед сургуулийн нийгэмд үйлчлэх үүрэг, нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх нь дэлхий нийтийн асуудал болжээ. Аливаа сургуулийн хамт олон юуны өмнө өөрсдийн сайн сайхан байдал, цалин хөлсний хүртээмжийн төлөө ажиллах бус олон нийт, нийгэмд үйлчлэх үүрэг, хариуцлагаа өндөржүүлэх нь чухлаар тавигдаж байна. Улсаас өгөх санхүүгийн дэмжлэгийн хэрээр түүний нийгэмд үйлчлэх үүрэг, нийгмийн хариуцлагын шаардлага нэмэгддэг зүй тогтолтой билээ. Тийм ч учраас 2021-2025 он хүртэлх стратегийн нэг гол тэргүүлэх чиглэлд сургуулийн нийгэмд үйлчлэх асуудлыг онцгойлон оруулж байна. Энэ хүрээнд сургуулийн нийгмийн хариуцлагын үзэл баримтлалаа нарийвчлан боловсруулах, нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг бүх хэлбэрээр хөгжүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн хариуцлагын стандартыг хэрэгжүүлж эхлэх, уг чиглэлд сургууль, тэнхим, хувь хүмүүсийн оруулж байгаа хувь нэмэр, үр дүнг хэмжиж, үнэлж, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх болно.

Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Шалгуур үзүүлэлт
Шинэ мэдлэг бий болгох, шинжлэх ухааны мэдлэг, ололтыг нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, соён гэгээрүүлэх, олон нийт, нийгэмд чиглэсэн үйлчилгээгээ нэмэгдүүлэх замаар сургуулийн нэр хүнд нийгмийн хариуцлагыг дээшлүүлнэ.	Нийгэмд чиглэсэн арга хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, санаачлагчийг урамшуулах, дэмжих бодлого баримтална.	Нийгмийн шинжтэй төлөвлөгөө, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа санаачилсан байдал, санаачлагчийг урамшуулсан бодлоготой эсэх
Багш, ажилтан, суралцагчдын нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаанд оролцох нөхцөл боломжийг бүрдүүлж, зарцуулсан хүч хөдөлмөрийг үнэлэх тогтолцоог нэвтрүүлнэ.	Нийгмийн сайн сайхны төлөө зарцуулсан хүч хөдөлмөрийг зохих ёсоор үнэлэх, үүний тулд холбогдох дүрэм, журмуудыг боловсруулна.	Суралцагчид, багш, сургуулийн захиргаанаас санаачилсан нийгмийн тустай ажлууд, тэдгээрийн үр өгөөж, нийгмийн тустай ажилд зарцуулсан мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө оруулалтын хэмжээ
Захиалгат сургалт, судалгааг хамтран гүйцэтгэх, сургалт явуулах зэргээр олон нийт, төр хувийн хэвшилтэй нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагаанаас үүсэх үр дүн, ач холбогдлыг нэмэгдүүлнэ.	Хамтын ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. Сургалтын модулиудыг бий болгох	Салбарын болон бусад байгууллагуудтай хамтарч ажилласан байдал, хамтын ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулсан эсэх, сургалтын арга хэлбэрт өөрчлөлт орсон эсэх

Дөрөв. 2021- 2025 ОН ХҮРТЭЛХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Стратегийн зорилт 1. Судалгаа, инновацын оновчтой бүтэц, тогтолцоог хөгжүүлэх

№	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцагчид	Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх арга хэлбэр
1	Судалгааны нээлттэй, өрсөлдөөнт, уян хатан тогтолцоог нэвтрүүлэх	2021--2023	Сургуулийн захиргаа	Багц цаг тооцох журам	Өрсөлдөөний шинжтэй урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх
2	Тэнхим хоорондын, багш нар хоорондын өрсөлдөөн бий болох	2021-2023	Сургалтын алба, стратеги хөгжлийн зөвлөл	Багц цаг тооцох журам	Судалгаа шинжилгээний ач холбогдлыг харгалзан урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх
3	Эрдэм шинжилгээ, инновацийн таатай орчин бүрдэх	2022--2025	Сургалтын алба, стратеги хөгжлийн зөвлөл	Бүтээлийн орлого, түншлэгчдийн ивээн тэтгэлэг	Инновацийн үр шимийг санаачлагчид ашигтайгаар хуваарилах тогтолцоог бий болгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх
4	Суралцагчдад орлого олох боломж олгох төсөл хэрэгжүүлэх, бичил үйлдвэрлэл хөгжих	2021--2025	Стратеги хөгжлийн зөвлөл	Бусад хөрөнгийн эх үүсвэрээр	Салбарын чиглэлээс хазайлгүйгээр уралдаант төсөл санаачлах, түүнийг хэрэгжүүлэх
5	Сургалтын бодлого орчин үеийн чиг хандлагатайгаар хөгжих	2021-2025	Сургалтын алба, стратеги хөгжлийн зөвлөл	Тухайн үеийн сургуулийн төсвөөр	Сургалтын орчин бүрдүүлэлт, сургалтын үйл ажиллагаанд техникийн дэвшлийг нэвтрүүлэх

Стратегийн зорилт 2. Нээлттэй, өрсөлдөөнд суурилсан чанартай сургалтын тогтолцоог төлөвшүүлэх

№	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцагчид	Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх арга хэлбэр
1	Суралцагчдыг элсүүлэх, сургах, судалгааны ажилд татан оруулах тогтолцоо бий болох	2021-2025	Сургуулийн захиргаа, сургалтын алба	Тухайн үеийн сургуулийн төсвөөр	Элсэлтийн журам шинэчлэх, сургалтын технологи шинэчлэх, суралцагчийн бүтээлч сэтгэлгээг дэмжих
2	Мэргэжлийн цар хүрээ нэмэгдэх, хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх тогтолцоо бий болох	2022-2025	Сургалтын алба, стратеги хөгжлийн зөвлөл	Бусад эх үүсвэр	Салбар хоорондын судалгаа, техникийн хөгжлийн судалгаа, хавсарга болон хос мэргэжлээр суралцах боломжийг нээх
3	Сонголтоос өрсөлдөөн, өрсөлдөөнөөс чанарт шилжсэн нээлтэй, сургалтын арга технологи бий болох	2023-2025	Сургалтын алба	Бусад эх үүсвэр	Суралцагчдад хөтөлбөрийн дэмжлэг үзүүлэх байдлаар багш, хичээл, мэргэжлээ өөрөө сонгох боломжийг олгох, цахим сургалтыг нэвтрүүлэх
4	Инженерийн сэтгэлгээг төлөвшүүлэх, дэмжих тогтолцоо бий болох	2021-2025	Стратеги хөгжлийн зөвлөл, судалгаа шинжилгээний баг	Бусад эх үүсвэр	Мэргэжлийн үр чадварын уралдаанууд, эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулах, багш суралцагчдын хамтарсан судалгааны ажлуудыг дэмжих, ивээн тэтгэгч олж өгөх
5	Тэнхимүүд өөрсдийн бизнес төлөвлөгөөтэй болох	2021-2022	Сургалтын алба, стратеги хөгжлийн зөвлөл	Бусад эх үүсвэр	Мэргэжлийн зэрэг ахиулах болон түр сургалт зохион байгуулах, тэнхимийн багш нарын хамтарсан болон бие даасан бүтээл түүнийг борлуулах

Стратегийн зорилт 3. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээг хөгжүүлэх

№	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцагчид	Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх арга хэлбэр
1	Суралцагчдад хүргэх үйлчилгээний стандарт батлагдаж хэрэгжих	2021-2022	Сургуулийн захиргаа, сургалтын алба	Бусад эх үүсвэр	Суралцагчийн дүрэм, журмыг шинэчлэх, тэдэнд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээний зураглалыг хийж, стандартыг батлуулж, мөрдөх
2	Санаачилгатай бүтээлч суралцагчийг ажил олгогчийн тэтгэлэгт хамруулах, мэргэжлийн үр чадвараа дээшлүүлэх цагийн ажлаар хангах	2023-2025	Сургалтын алба, стратеги хөгжлийн зөвлөл	Бусад эх үүсвэр	Улсаас өгч байгаа тэтгэлгээс гадна сургуулийн зүгээс идэвхжүүлэх, тусалж дэмжих зорилго бүхий тэтгэлэг, тэтгэмжийн хэмжээ, багшийн хүлээсэн үүрэгт суралцагчийн үзүүлсэн нөлөөллийн үр дүнг тооцох
3	Оюутны хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог бүрдэх	2022-2025	Сургуулийн захиргаа, Сургалтын алба	Бусад эх үүсвэр	Эчнээ, өдрийн, гарагийн ангиуд нээх, ажлын байрнаас хөндийрүүлэхгүйгээр дахин суралцуулах, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, бусад төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах
4	Судлаач, шинийг санаачлагч оюутан бий болох	2021-2025	Стратеги хөгжлийн зөвлөл, сургалтын алба	Бусад эх үүсвэр	Оюутныг бие даан судлах, шинийг бүтээх, санаачлах ажилд татан оролцуулах дэмжих
5	Оюутны сурч, хичээллэж, амьдрах таатай орчин, ахуй бүрдэх	2021-2025	Сургалтын алба, стратеги хөгжлийн зөвлөл	Тухайн үеийн сургуулийн төсвөөр	Дотуур байр, анги танхим, сургуулийн орчны тав тухтай байдлыг хангах

Стратегийн зорилт 4. Сургалт дадлагын орчныг сайжруулах

№	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцагчид	Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх арга хэлбэр
1	Шилдэг технологид суурилсан мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлнэ	2021-2025	Стратеги хөгжлийн зөвлөл, сургалтын алба	Бусад эх үүсвэр	Сургалтын цахим бүртгэлийн программыг нэвтрүүлэх, Цахим сургалтын системийг нэвтрүүлэх, Цахим номын сан, цахим шалгалтын системийг нэвтрүүлэх
2	Сургалтын лабораториудтай болох, сургалтын полигоныг иж бүрэн тоноглох	2021-2025	Стратеги хөгжлийн зөвлөл, сургуулийн удирдах зөвлөл	Бусад эх үүсвэр	Салбарын шинэчлэлт, техник технологийн дэвшлийг судлах, сургалтын полигоныг баяжуулах, сэлбэх, тоноглох
3	Хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах	2021-2025	Стратеги хөгжлийн зөвлөл, сургалтын алба, нэгж	Бусад эх үүсвэр	Мэргэжлийн боловсролыг дэмжиж ажилладаг донор байгууллагуудад төсөл хүргэж, санхүүгийн дэмжлэг авах
4	Сургуулийн хотхон бий болох	2023-2025	Стратеги хөгжлийн зөвлөл, удирдах зөвлөл	Төслийн санхүүжилт	Сургуулийн хотхон байгуулах төсөлтэй болох, хотхоныг бий болгох, хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох

Стратегийн зорилт 5. Удирдлага хүний нөөцийн оновчтой бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх

№	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцагчид	Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх арга хэлбэр
1	Дотоод үйл ажиллагааны нэгдмэл стандартыг бий болгож, нэвтрүүлэх	2021-2023	СУРГУУЛИЙН ЗАХИРГАА, ЧБССХА /ХШУДА/	Бусад эх үүсвэр	Сургуулийн дотоод үйл ажиллагааны дүрэм журмуудыг боловсронгуй болгож мөрдүүлэх, стандартчилагдсан үйлчилгээ болгон хөгжүүлнэ.
2	Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бүтээлтэй, арга ажиллагаатай шилдэг судлаач багш нарыг татах, хамтарч ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	2021-2025	Сургалтын алба, стратеги хөгжлийн зөвлөл	Бусад эх үүсвэр	Судлаач багш нарын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр
3	Хүний нөөцийн удирдлага, төлөвлөлтийг боловсронгуй болгох	2021-2025	Сургуулийн захиргаа, Сургалтын алба	Бусад эх үүсвэр	Удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсронгуй болгох, сонголт ба өрсөлдөөнийг дэмжсэн хүний нөөцийн бодлоготой болох
4	Багшийн хөгжлийг дэмжих	2020-2023	Стратеги хөгжлийн зөвлөл, сургалтын алба	Тухайн үеийн сургуулийн төсвөөр	Багшийн хөгжлийг үнэлж, дэмжих, сургуулиас тодорхой төсөв, төлөвлөгөө гаргаж ажиллах

Стратегийн зорилт 6. Нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг дээшлүүлэх

№	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцагчид	Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэх арга хэлбэр
1	Шинэ мэдлэг бий болгох, шинжлэх ухааны мэдлэг, ололтыг нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, соён гэгээрүүлэх, олон нийт, нийгэмд чиглэсэн үйлчилгээгээ нэмэгдүүлэх замаар сургуулийн нэр хүнд, нийгмийн хариуцлагыг дээшлүүлнэ.	2021-2023	Сургуулийн захиргаа, сургалтын алба	Бусад эх үүсвэр	Нийгэмд чиглэсэн арга эхмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, түүнийг санаачлагчийг урамшуулан дэмжих бодлого баримтална.
2	Багш суралцагсад нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаанд оролцох нөхцөл боломжийг бүрдүүлж, зарцуулсан хүч хөдөлмөрийг үнэлэх тогтолцоог нэвтрүүлнэ.	2021-2025	Сургалтын алба, стратеги хөгжлийн зөвлөл	Бусад эх үүсвэр	Нийгмийн сайн сайхны төлөө зарцуулсан хүч хөдөлмөрийг зохих ёсоор үнэлэх, үүний тул холбогдох дүрэм журмуудыг боловсруулна.
3	Захиалгат сургалт, судалгааг хамтран гүйцэтгэх, сургалт явуулах зэргээр олон нийт, төр, хувийн хэвшилтэй нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагаанаас үүсэх үр дүн нэмэгдэнэ.	2021-2025	Сургуулийн захиргаа, Сургалтын алба	Тухайн үеийн орлогоор	Хамтын ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. Бүтцийг өөрчилж, сургалтын модулиудыг бий болгох

ТАВ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ, ХЯНАЛТ, ТОДОТГОЛ

Сургуулийн удирдлага **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ** хэрэгжилтийн явцын тайланг жил бүр гаргаж багш ажилтнууд болон сургуулийн Удирдах зөвлөлд тайлагнана. Удирдах зөвлөл нь **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ** хэрэгжилтийн үр дүнг үнэлж, шаардлагатай тодотголуудыг хийх чиглэлийг гаргаж өгнө.

Жил бүр тайланг хэлэлцэхээс гадна уг төлөвлөгөөний биелэлтэнд доорх графикаар дунд хугацааны үнэлгээг 3 үечилж хийнэ.

- I үе шат буюу 2021-2022 оны ажлын үр дүнгийн үнэлгээ
- II үе шат буюу 2022-2023 оны ажлын үр дүнгийн үнэлгээ
- III үе шат буюу 2024-2025 оны ажлын үр дүнгийн үнэлгээ